



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 01 дугаар  
сарын 27-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

## Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1-28.3 дахь заалтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл-д, тогтоолын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн Ажлын алба /Ц.Амартөгс/-д даалгасугай.

Үндэсний зөвлөлийн дарга,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайд



Н.НОМТОЙБАЯР

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн  
дарга

Д. ХАДХҮҮ



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн  
2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн  
хурлын хоёрдугаар тогтоолын хавсралт

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн эрх, үүрэг, түүний удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах зөвшилцлийн байгууллага байна.

1.3. Аймгийн зөвлөл нь сум, багийн, нийслэлийн зөвлөл нь дүүрэг, хорооны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

### Хоёр. Зөвлөлийн эрх үүрэг

#### Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрхэн биелүүлж байгаа талаарх тайлан, мэдээлэл авах, хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

2.1.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн орон нутагт зохион байгуулах, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж Иргэдийн төлөөлөгчдийн хурал, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

2.1.3. хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтэс болон Засаг даргын тамгын газар бусад нэгжүүдийн ажлыг уялдуулан зохицуулах;

2.1.4. хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих;

2.1.5. тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах;

2.1.6. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан, мэдээлэл авах, хэлэлцэх, зөвлөмж гаргах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсөвт хуваарилуулах санал оруулах;

2.1.7. хөдөлмөр эрхлэлт дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах сум, хорооны хуваарийг тухайн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан батлах, бодлого, чиглэл гаргах;

2.1.8. аймаг, нийслэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг дүүрэг, хороо, сум, баг, иргэнд үр өгөөжтэй хүргэхэд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллагын ажил үүргийг чиглүүлж удирдлагаар хангах.

## **2.2. Зөвлөл дор дурьдсан үүрэгтэй байна:**

2.2.1. Төсвийн тухай хуулийн 58.1.58, 58.2.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2 дахь заалтын дагуу орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил бүр тусган батлуулах;

2.2.2. аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах;

2.2.3. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц, байдал, үүний дотор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих;

2.2.4. тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах;

2.2.5. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийгмийн болон төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмуудыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжих, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах;

2.2.6. орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах;

2.2.7. хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгууллага, ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, гэр бүл, залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаа уялдуулах;

2.2.8. тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүрийн 1 дугаар сард ирүүлж байх;

2.2.9. үндэсний зөвлөлийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдамж, зөвлөмжийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, томилсон байгууллагадаа ажлаа тайлагнах болон удирдан зохицуулах, хяналт үнэлгээ хийхдээ ашиглах шалгуур үзүүлэлтүүд зэргийг үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж хэрэгжүүлэх.

### **Гурав. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт**

3.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга 4 жилийн хугацаагаар батална. Зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байх бөгөөд гурван талын төлөөлөгчдийн тоо адил бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

3.1.1. төрийг төлөөлж Засаг дарга болон аймаг, нийслэл, дүүргийн боловсрол болон нийгмийн хөгжил, төсөв санхүүгийн байгууллагаас нийт гурван хүн;

3.1.2. ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван хүн;

3.1.3. ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах орон нутгийн ажил олгогчдын байгууллагаас гурван хүн.

3.2. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга түр эзгүй байх тохиолдолд зөвлөлийн даргын үүргийг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч гүйцэтгэнэ.

3.3. Орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн болон ажил олгогчдын байгууллагууд энэхүү дүрмийн 3.1.2 болон 3.1.3-т заасан төлөөллийг бүрдүүлэхдээ тухайн орон нутгийн тэргүүлэх салбарын ажил олгогч болон ажилтны байгууллагаас оролцуулах бөгөөд түүнчлэн харилцан зөвшилцсөнөөр мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөгчийг бүрэлдэхүүндээ оруулж болно.

3.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гурван тал тус бүрээс 2 гишүүн, нийт 6-гаас доошгүй гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

3.5. Зөвлөл нь хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн хуралдаанаас эрх, үүргийнхээ хүрээнд санал дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах бөгөөд хуралдааны тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулна. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.6. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан тэмдэглэл, санал дүгнэлт, зөвлөмж, тогтоолыг гишүүдэд танилцуулан, зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.7. Зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр гишүүний оролцоог харгалзан зөвлөлийн нарийн бичгийг даргыг хамруулан урамшуулал олгоно. Урамшуулал болон зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр

эрхлэлтийн байгууллагын төсөвт тусган Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

3.8. Зөвлөлийн ажлын албаны үүргийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга байна.

3.9. Зөвлөлийн шийдвэрийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.10. Зөвлөлд төрийг төлөөлж буй гишүүд нь Засаг даргад, Засаг дарга нь үр дүнгийн гэрээний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад, ажилтны төлөөллийн гишүүд нь орон нутгийн болон үйлдвэрчний эвлэлийн үндэсний хэмжээний байгууллагад, ажил олгогчийн төлөөллийн гишүүд нь орон нутгийн болон ажил олгогчдын үндэсний хэмжээний байгууллагад хийсэн ажлаа тайлагнана.